



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/35

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Боловсролын тухай хуулийн 30.1, 30.1.2 дахь заалт, Бага дунд боловсролын тухай хуулийн 5.1.1, 6.1.3 дахь хэсэг, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2020 оны А/200 дугаар тушаал, Боловсролын ерөнхий газрын 2022 оны 1/2691 дүгээр тоот зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтын сургалт, үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
дарга:
Гишүүд:

Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
Боловсролын хэлтсийн дарга
Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн
хэлтсийн дарга
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний
хэлтсийн дарга
Насан туршийн боловсролын төвийн
багш
Засаг даргын тамгын газрын боловсрол,
соёл, урлаг хариуцсан мэргэжилтэн

Нарийн бичгийн
дарга:

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний
хэлтсийн хөдөлмөр эрхлэлтийн албаны
дарга

2. Дүүргийн хүүхэд залуучууд, иргэдэд, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжил сонголтын сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулан хагас жил тутам тайлагнаж ажиллахыг ажлын хэсэг (Б.Цогжавхлан)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2023 он ажилга захирамж

1123000198